



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 10 сарын 01 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот


2020 оны орон нутгийн сонгуулийн  
сонгогчдын санал авах хэсэг, түүний хамрах нутаг дэвсгэр,  
төвийг тогтоох тухай тогтоолын хавсралтад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 25 дугаар зүйлийн 25.1, 25.2, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Баянгол дүүргийн Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Засаг даргын орлогчийн 2020 оны 09 дүгээр сар 30-ны өдрийн 01/2175 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 31 дүгээр тогтоолын хавсралтын 5 дугаарт бичигдсэн хэсгийн төв хэсгийн 2 дугаар хороонд хамаарах Төмөр замын харьяа Төмөр замын дуу бүжгийн чуулгын их засварын ажил дуусаагүй байх тул "Төмөр замын харьяа Төмөр замын дуу бүжгийн чуулга" гэснийг "66 дугаар цэцэрлэг" гэж өөрчилсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Э.Энхзаяа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



ГЭНХБОЛД

104080076